



**МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ**

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 81

Улаанбаатар хот

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
бүртгэл, үйл ажиллагааны журам”-ыг батлах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2, 11 дүгээр зүйлийн 11.10, 11.12 дахь хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба (Т.Жамбаажамц)-нд даалгасугай.

ДАРГА

Д.БАЯРСАЙХАН

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН БҮРТГЭЛ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Энэ журмаар Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “Хороо” гэх)-оос барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд, байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэнээр бүртгүүлэх өргөдөл гаргагч (цаашид “өргөдөл гаргагч” гэх)-ийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах, бүртгэлтэй этгээдийн үйл ажиллагаанд тавигдах шаардлагыг тогтоохтой холбогдсон харилцааг зохицуулна.

Хоёр.Өргөдөл гаргагчид тавигдах шаардлага

2.1.Өргөдөл гаргагч нь Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 5.1-д зааснаас гадна дараах шаардлагыг хангасан байна:

2.1.1.хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийн эх үүсвэр нь баримтаар тодорхойлж, нотлох боломжтой хууль ёсны орлого байх;

2.1.2.цахим мэдээллийн санд мэдээлэл илгээх, хүлээн авах, дотоод бүртгэл мэдээллийг хөтлөх боломжтой компьютер, техник, тоног төхөөрөмжтэй байх;

2.1.3.барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд бол холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан дуу-дүрсний бичлэгийн төхөөрөмжийг аюулгүй байдал хангах зорилгоор ажлын байранд байршуулсан байх.

Гурав.Өргөдөл гаргагчийг бүртгэх, бүртгэхээс татгалзах

3.1.Өргөдөл гаргагч нь энэ журмын нэгдүгээр хавсралтаар баталсан өргөдөл, хавсаргах баримт бичгийг бүрдүүлж, Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 9.1, 9.2-г заасны дагуу аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл Санхүүгийн зохицуулах хороо (цаашид “бүртгэх байгууллага” гэх)-д цаасаар, эсхүл цахимаар ирүүлнэ.

3.2.Бүртгэх байгууллага өргөдөл гаргагчийн бүртгүүлэх өргөдлийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан хугацаанд хянаж, шийдвэрлэнэ.

3.3.Өргөдөл гаргагчийн баримт бичиг бүрдэл дутуу, нотлох баримт нь шаардлага хангаагүй бол бүртгэх байгууллага нь өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэж, нэмэлт баримт бичгийг шаардаж болно.

3.4.Энэ журмын 3.2-т заасан хугацааг зохих шаардлага хангасан, бүрдэл бүрэн баримт бичгийг ирүүлсэн өдрөөс эхлэн тоолно.

3.5.Бүртгэх байгууллага нь өргөдөл гаргагчийг Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 11.4, 11.5, 11.8-д заасан үндэслэлээр бүртгэхээс татгалзана.

3.6.Бүртгэх байгууллага нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгэсэн тохиолдолд улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримтыг үндэслэн хувийн дугаар, гэрчилгээг олгож, зохих журмын дагуу бүртгэлийн цахим санд бүртгэж, нийтэд мэдээлнэ.

Дөрөв.Хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн өөрчлөлт

4.1.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцааны тоо, хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах, байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэний тухайн үйл ажиллагаанд ашиглах мөнгөн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах тохиолдолд энэ журмын хоёрдугаар хавсралтаар баталсан өргөдөл, хавсаргах баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад цаасаар, эсхүл цахимаар тухай бүр ирүүлнэ.

4.2.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэний тухайн үйл ажиллагаанд ашиглах мөнгөн хөрөнгө нэмэгдэх тохиолдолд мөнгөн хөрөнгийн эх үүсвэр хууль ёсны болохыг өргөдөл гаргагч өөрөө тодорхойлж, нотолно.

4.3.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд нь энэ журмын 4.2-т заасан мөнгөн хөрөнгийг мөнгөн зээлийн үйл ажиллагаанд зориулсан харилцах дансандаа байршуулсан талаарх банкны тодорхойлолт, дансны хуулгыг ирүүлэх бөгөөд бүртгэх байгууллагын шийдвэр гарахаас өмнө дансны үлдэгдлийг эрх бүхий этгээд шалган баталгаажуулж болно.

4.4.Бүртгэх байгууллага өргөдлийг хянаж, шийдвэрлэх хүртэлх хугацаанд өргөдөл гаргагч нь байршуулбал зохих мөнгөн хөрөнгийн хэмжээг бууруулж, зарлагын гүйлгээ хийхгүй.

4.5.Энэ журмын 4.1-д заасны дагуу ирүүлсэн баримт бичиг бүрдэл дутуу, нотлох баримт нь шаардлага хангаагүй бол бүртгэх байгууллага өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэж, нэмэлт баримт бичгийг ажлын таван өдрийн дотор ирүүлэхээр шаардаж болно.

4.6.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэний тухайн үйл ажиллагаанд ашиглах мөнгөн хөрөнгийн хэмжээ өсөж, буурахаас үл хамааран анх бүртгэсэн байгууллага Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан хугацаанд хянаж, бүртгэлдээ өөрчлөлт оруулна.

4.7.Бүртгэх байгууллага энэ журмын 4.1-д заасан өргөдөлтэй холбогдох өөрчлөлтийг дараах үндэслэлээр бүртгэхээс татгалзаж, өргөдөл гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ:

4.7.1.өөрчлөлт оруулах хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгө нь хууль ёсны орлого болох нь нотлогдоогүй;

4.7.2.энэ журмын 4.4-д заасныг зөрчиж, мөнгөн хөрөнгөөс зарлагын гүйлгээ хийсэн;

4.7.3.энэ журмын 4.5-д заасан хугацааг хэтрүүлсэн, эсхүл ирүүлсэн баримт бичиг нь бүрдэл дутуу, нотлох баримт нь шаардлага хангаагүй;

4.7.4.хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн хэмжээг хорогдуулах нь санхүү, төлбөрийн чадварт сөргөөр нөлөөлөх, бусад хувьцаа эзэмшигч, харилцагчдад хохирол учруулахаар бол;

4.7.5.хуулийн этгээдийн хувьд холбогдох өөрчлөлт оруулахаар шийдвэрлэсэн эрх бүхий этгээдийн шийдвэр болон гэрээ, хэлцэл нь хуулийн шаардлага хангахгүй, эсхүл хуурамч болох тогтоогдсон.

Тав.Салбарын өөрчлөлт

5.1.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд нь салбар байгуулах тохиолдолд энэ журмын гуравдугаар болон тавдугаар хавсралтаар баталсан өргөдөл, хавсаргах баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад цаасаар, эсхүл цахимаар ирүүлнэ.

5.2.Салбарын менежерт Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 7.1-д заасан, салбарын үйл ажиллагаа явуулах ажлын байранд Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 5.1.6-д заасан шаардлага тус тус тавигдана.

5.3.Энэ журмын 5.1-д заасны дагуу ирүүлсэн баримт бичиг бүрдэл дутуу, нотлох баримт нь шаардлага хангаагүй бол бүртгэх байгууллага өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэж, нэмэлт баримт бичгийг ажлын таван өдрийн дотор ирүүлэхээр шаардаж болно.

5.4.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд салбар байгуулах тохиолдолд байршлаас үл хамааран анх бүртгэсэн байгууллага Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан хугацаанд хянаж, бүртгэлдээ өөрчлөлт оруулна.

5.5.Бүртгэх байгууллага дараах үндэслэлээр салбарыг бүртгэхээс татгалзаж, өргөдөл гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ:

5.5.1.салбарын байгуулах нь тухайн хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндрэл учруулахаар байгаа бол;

5.5.2.салбар байгуулахаар шийдвэрлэсэн эрх бүхий этгээдийн шийдвэр болон гэрээ, хэлцэл нь хуулийн шаардлага хангахгүй, эсхүл хуурамч болох тогтоогдсон;

5.5.3.хууль тогтоомж, энэ журамд заасан шаардлагыг хангаагүй;

5.5.4.энэ журмын 5.3-д заасан хугацааг хэтрүүлсэн, эсхүл ирүүлсэн баримт бичиг нь бүрдэл дутуу, нотлох баримт нь шаардлага хангаагүй.

5.6.Бүртгэх байгууллага дараах үндэслэлээр салбарын бүртгэлийг хүчингүй болгож, гэрчилгээг хураан авна:

5.6.1.өөрийн хүсэлтээр;

5.6.2.салбарын үйл ажиллагаа нь тухайн хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагаа, санхүү, төлбөрийн чадварт хүндрэл учруулахаар байгаа нь тогтоогдсон;

5.6.3.хууль тогтоомж, энэ журамд заасан шаардлагыг хангахгүй болсон.

Зургаа.Гүйцэтгэх удирдлага, оноосон нэр, хаяг байршлын өөрчлөлт

6.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хаяг байршил, барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлага өөрчлөгдөх тохиолдолд энэ журмын тавдугаар хавсралтаар баталсан өргөдөл, хавсаргах баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад цаасаар, эсхүл цахимаар ирүүлнэ.

6.2.Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн оноосон нэр өөрчлөгдөх тохиолдолд энэ журмын дөрөвдүгээр хавсралтаар баталсан өргөдөл, хавсаргах баримт бичгийг бүрдүүлж, бүртгэх байгууллагад цаасаар, эсхүл цахимаар ирүүлнэ.

6.3.Энэ журмын 6.1, 6.2-д заасны дагуу ирүүлсэн баримт бичиг бүрдэл дутуу, нотлох баримт нь шаардлага хангаагүй бол бүртгэх байгууллага өргөдөл гаргагчид бичгээр мэдэгдэж, нэмэлт баримт бичгийг ажлын таван өдрийн дотор ирүүлэхээр шаардаж болно.

6.4.Энэ журмын 6.1, 6.2-т заасан өргөдлийг байршлаас үл хамааран анх бүртгэсэн байгууллага Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуульд заасан хугацаанд хянаж, бүртгэлдээ өөрчлөлт оруулна.

6.5. Бүртгэх байгууллага дараах үндэслэлээр энэ журмын 6.1, 6.2-т заасан өргөдлийг бүртгэхээс татгалзаж, өргөдөл гаргагчид албан бичгээр мэдэгдэнэ:

6.5.1.өөрчлөлт нь тухайн хуулийн этгээдийн хэвийн үйл ажиллагаанд сөрөг нөлөөлөл, хүндрэл учруулахаар бол;

6.5.2.өөрчлөлт оруулах тухай эрх бүхий этгээдийн шийдвэр болон гэрээ, хэлцэл нь хуулийн шаардлага хангахгүй, эсхүл хуурамч болох тогтоогдсон;

6.5.3.хууль тогтоомж, энэ журамд заасан шаардлагыг хангаагүй;

6.5.4.энэ журмын 6.3-д заасан хугацааг хэтрүүлсэн, эсхүл ирүүлсэн баримт бичиг нь бүрдэл дутуу, нотлох баримт нь шаардлага хангаагүй.

Долоо.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагаа

7.1.Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээд мөнгөн зээлийн үйл ажиллагаандаа хуульд зааснаас гадна дараах шаардлагыг хангаж ажиллана:

7.1.1.өөрийн үйл ажиллагааны талаар харилцагч, үйлчлүүлэгчид үнэн зөв мэдээлэл өгөх;

7.1.2.зээл хүсэгч, барьцаа, батлан даалт гаргах этгээдийг тухайн этгээд мөн эсэхийг албан ёсны бичиг баримтаар баталгаажуулах, харилцагчийг таньж мэдэх;

7.1.3.зээлийн гэрээ байгуулахдаа Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 15.3, 15.5-д заасан үүргээ биелүүлснээ нотолж, баталгаажуулах;

7.1.4.цахим (финтек)-аар зээлийн бүтээгдэхүүн гаргахгүй, зээл, барьцаа, батлан даалтын гэрээ байгуулахгүй байх;

7.1.5.галт зэвсэг, түүнтэй адилтгах хэрэгсэл, сум, тэсэрч дэлбэрэх зүйл, хорт болон химийн бодис, хүнсний бүтээгдэхүүн, иргэний, жолооны, албаны үнэмлэх, түүнтэй адилтгах баримт бичиг, хуулийн этгээдийн аливаа үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, лиценз, бусад эрхийн бичиг, археологи, палеонтологийн олдворын зүйлийг барьцаанд авахгүй байх;

7.1.6.барьцаалсан хөдлөх эд хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хариуцаж, барьцаанд тавьсан эд зүйлийг зээлдэгч, барьцаалуулагчийн дэргэд битүүмжлэн, тусгай тэмдэглэгээ тавьж лацдах;

7.1.7.зээлдэгч, барьцаалуулагчийн эд хөрөнгийг барьцаанд хүлээн авах, буцаан олгохдоо хүлээлцсэн тухай баталгаажуулсан байх;

7.1.8.гэрээний хугацаанд барьцаа хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, аюулгүй байдлыг хангах;

7.1.9.Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 16.2-т заасан цахим мэдээллийн санд бүртгэгдсэн сэжиг бүхий эд зүйлийн талаар цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

7.1.10.мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлдэг байх;

7.1.11.Хорооноос тогтоосон зохицуулалтын үйлчилгээний хөлс төлөх.

Найм.Бусад

8.1.Бүртгэх байгууллага нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийг бүртгэх, бүртгэлд өөрчлөлт оруулах үйл ажиллагааг Хорооны цахим системээр дамжуулан гүйцэтгэнэ.

8.2.Бүртгэх байгууллага шаардлагатай тохиолдолд энэ журамд заасны дагуу өргөдөл гаргагчаас ирүүлсэн баримт бичгийн талаар холбогдох этгээдээс тодруулах, дүгнэлт гаргуулах, лавлагаа авах, ажлын байр, тоног төхөөрөмж, программ хангамж нь шаардлага хангасан эсэхийг шалгах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж болно.

8.3.Бүртгэх байгууллага нь албан бичгээр ирүүлсэн хүсэлтийг үндэслэн Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 24.1-д заасны дагуу түдгэлзүүлсэн үндэслэл болох алдаа, зөрчлийг хугацаандаа арилгасан гэж үзвэл тухайн этгээдийн үйл ажиллагааг сэргээж болно.

8.4.Бүртгэх байгууллагын түдгэлзүүлсэн шийдвэр нь түдгэлзүүлэхээс өмнө байгуулсан зээл, барьцаа, батлан даалтын гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахтай холбогдох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үйл ажиллагааг хязгаарлахгүй.

----oOo----

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын нэгдүгээр хавсралт

**МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭЭР
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагчийн нэр						
Улсын бүртгэлийн дугаар						
Регистрийн дугаар						
Хэсэг 1. Эрхлэх үйл ажиллагааны төрлөө сонгоно уу.						
<input type="radio"/> Барьцаалан зээлдүүлэх журмаар мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд <input type="radio"/> Байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн						
Хэсэг 2. Өргөдөл гаргагчийн мэдээлэл						
Өмнө нь мөнгөн зээлийн үйл ажиллагаа явуулж байсан эсэх				<input type="radio"/> Тийм		<input type="radio"/> Үгүй
Мөнгөн зээлийн үйл ажиллагаа явуулж байсан хугацаа (жилээр)						
Үүсгэн байгуулагдсан огноо	Он		Сар		Өдөр	
Этгээдийн хэлбэр	<input type="radio"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани <input type="radio"/> Нөхөрлөл <input type="radio"/> Иргэн					
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="radio"/> Дотоодын <input type="radio"/> Гадаадын					
Хаяг байршил	Аймаг/ хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж,байр					
	Тоот					
	Холбоо барих утас					
Цахим шуудангийн хаяг						
Цахим хуудас						
Үйл ажиллагаа явуулах ажлын байр		<input type="radio"/> Худалдаж авсан <input type="radio"/> Түрээсэлсэн <input type="radio"/> Бусад				
Хуулийн этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгийн талаарх мэдээлэл: (Доорх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)						
Хувьцаа эзэмшигчийн овог нэр/оноосон нэр	Хувьцааны тоо ширхэг	Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (₮)		Хувь нийлүүлсэн хөрөнгөд эзлэх хувь (%)		
Иргэний мөнгөн хөрөнгийн талаарх мэдээлэл:						

Иргэний овог нэр/Регистрийн дугаар	Харилцагч банк	Банкин дахь харилцах дансны үлдэгдэл (₮)
Хэсэг 3. Үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл		
1. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд		
Хуулийн этгээдийн оноосон нэр		
Улсын бүртгэлийн дугаар		
Регистрийн дугаар		
Үүсгэн байгуулагдсан огноо	Он	Сар
		Өдөр
Хуулийн этгээдийн хэлбэр	<input type="radio"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани <input type="radio"/> Нөхөрлөл	
Хөрөнгө оруулалтын хэлбэр	<input type="radio"/> Дотоодын <input type="radio"/> Гадаадын	
Бизнесийн үйл ажиллагааны чиглэл		
Үйл ажиллагааны орлого	₮	
Үйл ажиллагааны зардал	₮	
Үйл ажиллагааны ашиг	₮	
Хаяг байршил	Аймаг/ хот	
	Сум/дүүрэг	
	Баг/хороо	
	Гудамж, байр	
	Тоот	
	Холбоо барих утас	
Цахим хуудас		
Цахим хаяг		
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх? (Тийм бол доорх мэдээллийг нэгдлийн оролцогч бүрээр бөглөнө үү)		<input type="radio"/> Тийм <input type="radio"/> Үгүй
Оноосон нэр		
Регистрийн дугаар		
Өргөдөл гаргагч хуулийн этгээдтэй ямар холбоотой болох	<input type="checkbox"/> толгой <input type="checkbox"/> охин	<input type="checkbox"/> хараат <input type="checkbox"/> зэргэлдээ
2. Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь иргэн бол		
Овог		
Нэр		
Регистрийн дугаар		
Эрхэлж байгаа ажил, албан тушаал		
Ажлын хаяг		
Эзэмшсэн мэргэжил		
Холбоо барих утас		
Хэсэг 4. Удирдлага мэргэшсэн хүний нөөцтэй холбоотой мэдээлэл		
(Доорх мэдээллийг удирдах ажилтан бүрээр бичнэ.)		
Нийт ажилтан, албан хаагчдын тоо		

Албан тушаал	Овог	Нэр	Харьяалал	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар
ГУЗ-ийн дарга							
ГУЗ-ийн гишүүн							
Гүйцэтгэх захирал							
Нягтлан бодогч							
Бусад							
Хэсэг 5. Ашиглах техник, тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээлэл (Доорх мэдээллийг техник, тоног төхөөрөмж бүрээр бичнэ.)							
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл		Техникийн үзүүлэлт	Худалдан авсан, түрээсэлсэн аль нь болох		Тоо ширхэг	Үнэ	
Программ хангамжийн нэр төрөл		Программын зориулалт	Худалдан авсан Түрээсэлсэн		Тоо ширхэг	Үнэ	
Тэмдэглэл: (Дээрх мэдээллийг программ хангамж бүрээр бичнэ.)							

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа мэдээлэл, нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв уг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг өөрөө хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдээр бүртгэж өгнө үү.

Бид үйл ажиллагаандаа Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд (тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ.):

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Албан тушаал: _____

Утасны дугаар: _____

Өргөдөл гаргагч:

Тэмдэг

_____/_____/_____
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

**МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДЭЭР БҮРТГҮҮЛЭХ
ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Өргөдөл, хүсэлт тавьсан албан бичиг	
2	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх тухай үүсгэн байгуулагчдын хурлын тэмдэглэл, шийдвэрийн эх хувь <i>(нэг үүсгэн байгуулагчтай бол тухайн этгээдийн шийдвэр)</i>	
3	Нэгээс илүү үүсгэн байгуулагч байгуулах нөхцөлд үүсгэн байгуулагчдын хамтран ажиллах гэрээ	
4	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, гадаадын хөрөнгө оруулалттай хуулийн этгээдийн хувьд гадаадын хөрөнгө оруулалтын гэрчилгээний хувь <i>(иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар)</i>	
5	Компанийн дүрмийн хувь	
6	Мөнгөн зээлийн үйл ажиллагаанд мөрдөх журам, холбогдох шийдвэр (Тайлбар: Барьцаалан зээлдүүлэх үйл ажиллагааны дотоод журамд барьцаа хөрөнгийн үнэлгээг тооцох аргачлал, барьцааны шаардлагыг хангах, худалдах, барьцааны эрх дуусгавар болох, мөнгөн зээлийн үйл ажиллагаатай холбоотой дотоод бүртгэл хөтлөх, түүнийг цахим мэдээллийн санд мэдээлэх болон эрх бүхий байгууллагатай мэдээлэл солилцох, хэрэглэгчийг хамгаалах зэрэг зохицуулалтыг тусгасан байвал зохино)	
7	Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийн орлогыг тодорхойлох баримт бичиг, мөнгөн хөрөнгийн гарал үүслийн тодорхойлолт А. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол тухайн жилүүдийн аудитлагдсан санхүүгийн тайлан, татварын тайлан, санхүүгийн тайлангийн хуулбар гэх мэт Б. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь иргэн бол нийгмийн даатгал, татварын тодорхойлолт, татвар төлсөн баримт, холбогдох гэрээ хэлцэл гэх мэт	
8	Хувь нийлүүлсэн мөнгөн хөрөнгийг санхүүгийн байгууллага дахь тухайн хуулийн этгээд (иргэн бол өөрийн)-ийн дансанд байршуулсан банкны тодорхойлолт, дансны хуулга	

9	<p>Барьцаалан зээлдүүлэх журмаар олгох мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдийн хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ:</p> <ol style="list-style-type: none"> 1. хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага, менежер нь журмын 6-р хавсралтаар баталсан эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт, анкет; 2. мэргэжлийн дипломын хуулбар; 3. мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх гүйцэтгэх удирдлага, менежерийн сургалтад хамрагдсаныг нотлох сертификатын хувь эсхүл сургалт явуулсан эрх бүхий байгууллагын тодорхойлолт; 4. Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах хуулийн 5.1.10-т заасан гэмт хэрэгт хариуцлага хүлээж байсан эсэх талаарх эрх бүхий байгууллагын тодорхойлолт; 5. эрх бүхий албан тушаалтан, холбогдох этгээд нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангасныг нотлох баримт бичиг; 6. гүйцэтгэх удирдлага, ажилтантай байгуулсан эрх бүхий этгээдийн томилсон шийдвэрийн хувь, хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт; <p>Байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэн нь энэ хэсгийн 1-5-д заасан шаардлагыг хангасан байна.</p>	
10	<p>Үйл ажиллагаа явуулах ажлын байр нь холбогдох шаардлага хангасныг нотлох баримт бичиг, тоног төхөөрөмж, программ хангамж, эд зүйлсийг гэрэл зургаар баталгаажуулах</p> <ol style="list-style-type: none"> 1. ажлын байрны цахилгаан болон галын аюулгүй байдлын шаардлага хангасныг нотлох эрх бүхий байгууллагын дүгнэлт; 2. үйл ажиллагаа явуулах ажлын байр нь өөрийн өмчлөл, эзэмшлийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хуулбар, түрээсийн байр бол түрээсийн гэрээний хуулбар; 	
11	<p>Бизнес төлөвлөгөө (3 жилээр), эхлэлтийн тайлан тэнцэл</p>	
12	<p>Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хуулийн дагуу хяналт тавих ажилтныг томилсон шийдвэр</p>	

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын хоёрдугаар хавсралт

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагч хуулийн этгээдийн оноосон нэр						
Өргөдөл гаргагч иргэний овог нэр						
Регистрийн дугаар						
Хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах						
<input type="checkbox"/> Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах оруулах <input type="checkbox"/> Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах <input type="checkbox"/> Байнга, ашиг олох зорилгоор мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх иргэний мөнгөн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах						
А. Хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүнд шинээр орж буй этгээдийн хувьд: (Доорх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)						
Оноосон нэр (Овог, нэр)	Регистрийн дугаар	Хувьцааны тоо (ш)	ХНХ хэмжээ (₮)	ХНХ-д эзлэх хувь (%)	Хаяг, утас	
Б. Хувьцаа эзэмшигчдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, иргэний мөнгөн хөрөнгөд өөрчлөлт орсон тохиолдолд: (Доорх мэдээллийг хувьцаа эзэмшигч бүрээр бичнэ.)						
Оноосон нэр (Овог, нэр)	Регистрийн дугаар	Одоогийн хөрөнгийн хэмжээ (₮)	Нэмэгдсэн (₮)	Хорогдсон (₮)	Өөрчлөлт орсон хөрөнгийн хэмжээ (₮)	Хөрөнгөд эзлэх хувь (%)
В. Хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл						

Хуулийн этгээдийн нэр	Эцсийн өмчлөгчийн нэр	Регистрийн дугаар	Хувьцаа эзэмшлийн хувь (%)	Хаяг	Утас
Г. Шинэ хувьцаа эзэмшигч компанийн нэгдлийн мэдээлэл					
Компанийн тухай хуулийн 6.14-д заасан компанийн нэгдлийн оролцогч эсэх? (тийм бол доорх мэдээллийг нэгдлийн оролцогч бүрээр бөглөнө үү)				<input type="checkbox"/> Тийм	<input type="checkbox"/> Үгүй
Оноосон нэр					
Компанийн хэлбэр		<input type="checkbox"/> Хувьцаат компани	<input type="checkbox"/> Хязгаарлагдмал хариуцлагатай компани		
Хүсэлт гаргагч компанитай ямар холбоотой болох		<input type="checkbox"/> толгой <input type="checkbox"/> охин	<input type="checkbox"/> хараат <input type="checkbox"/> зэргэлдээ		
Байгуулагдсан огноо		Он		Сар	Өдөр
Үйл ажиллагааны төрөл					
Хаяг	Аймаг/ хот				
	Сум/дүүрэг				
	Баг/хороо				
	Гудамж, байр				
	Тоот				
Холбоо барих утас					
Цахим хуудас					
Цахим хаяг					

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа мэдээлэл, нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв уг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг өөрөө хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгийн өөрчлөлтийг бүртгэж өгнө үү.

Бид үйл ажиллагаандаа Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд (тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ.):

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Албан тушаал: _____

Утасны дугаар: _____

Өргөдөл гаргагч:

Тэмдэг _____ / _____ /
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

**МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН
ХӨРӨНГӨ, МӨНГӨН ХӨРӨНГИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Өргөдөл, хүсэлт тавьсан албан бичиг	
2	Өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр, холбогдох гэрээ хэлцэл, нотлох баримт бичиг	
3	Иргэний хуулийн дагуу өмчлөх эрхээ өвлүүлсэн, бэлэглэсэн тухай хэлцэл, нотлох баримт бичиг	
4	Нэгээс олон хувьцаа эзэмшигчтэй тохиолдолд хувьцаагаа худалдахаар санал болгож байгаа хувьцаа эзэмшигчийн хүргүүлсэн саналыг бусад хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсэн албан бичиг	
5	<p>Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувь нийлүүлсэн хөрөнгө, мөнгөн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийн орлогыг тодорхойлох баримт бичиг, мөнгөн хөрөнгийн гарал үүслийн тодорхойлолт</p> <p>А. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол тухайн жилүүдийн аудитлагдсан санхүүгийн тайлан, татварын тайлан, санхүүгийн тайлангийн хуулбар гэх мэт</p> <p>Б. Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч нь иргэн бол нийгмийн даатгал, татварын тодорхойлолт, татвар төлсөн баримт, холбогдох гэрээ хэлцэл гэх мэт</p>	
6	Хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулах мөнгөн хөрөнгийг санхүүгийн байгууллага дахь тухайн хуулийн этгээд(иргэн бол өөрийн)-ийн дансанд байршуулсан банкны тодорхойлолт, дансны хуулга	
7	Нэмэлт өөрчлөлт оруулсан дүрмийн хувь	

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын гуравдугаар хавсралт

**БАРЬЦААЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЖУРМААР ОЛГОХ МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САЛБАРЫГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ**

Салбар байгуулах шийдвэр	Он		Сар		Өдөр		Дугаар	
Хаяг байршил	Аймаг/ хот							
	Сум/дүүрэг							
	Баг/хороо							
	Гудамж,байр							
	Тоот							
	Холбоо барих утас							
Цахим хуудас								
Цахим хаяг								
Салбарын удирдах албан тушаалтны мэдээлэл (Доорх мэдээллийг удирдах ажилтан бүрээр бичнэ.)								
Нэгжийн нийт ажилтан, албан хаагчдын тоо								
Албан тушаал	Овог	Нэр	Регистрийн дугаар	Утасны дугаар	Эзэмшсэн мэргэжил	Дипломын дугаар		
Менежер								
Нягтлан бодогч								
Бусад ажилтан								
Үйл ажиллагаа явуулах ажлын байрны мэдээлэл								
Өртөг зардлын мэдээлэл	<input type="checkbox"/> Худалдаж авсан		<input type="checkbox"/> Түрээсэлсэн		<input type="checkbox"/> Бусад			
Сард гарах төлбөр ₮								
Ашиглах техник тоног төхөөрөмж, программ хангамжийн мэдээлэл (Доорх мэдээллийг техник, тоног төхөөрөмж, программ хангамж бүрээр бичнэ.)								
Техник, тоног төхөөрөмжийн нэр төрөл	Техникийн үзүүлэлт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Бусад	Тоо ширхэг	Үнэ ₮		
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				
Программ хангамжийн нэр төрөл	Программын зориулалт	Худалдан авсан	Түрээсэлсэн	Бусад	Тоо ширхэг	Үнэ ₮		
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				
		<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>				

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа мэдээлэл, нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв уг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг өөрөө хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, салбар байгуулах хүсэлтийг бүртгэж өгнө үү.

Бид үйл ажиллагаандаа Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд (тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ.):

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Албан тушаал: _____

Утасны дугаар: _____

Өргөдөл гаргагч:

Тэмдэг

_____ / _____ /
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

**БАРЬЦААЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЖУРМААР ОЛГОХ МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САЛБАРЫГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛД
(ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Баримт бичгийн төрөл	Хуудасны тоо
1	Өргөдөл, хүсэлт тавьсан албан бичиг	
2	Салбар байгуулах, салбарын удирдлагыг томилох тухай төлөөлөн удирдах зөвлөлийн хурал /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ын тэмдэглэл, шийдвэр	
3	Нэмэлт өөрчлөлт оруулсан дүрэм	
4	Салбар байгуулах, түүний эрх, үүрэг, өөрчлөн байгуулах, татан буулгах болон бусад харилцааг зохицуулсан журам	
5	Нэмэлт өөрчлөлт оруулсан дотоод хяналтын албаны журам /дотоод хяналтын албаны үйл ажиллагаа нь дүрмээр зохицуулагддаг бол нэмэлт өөрчлөлт оруулсан дүрэм/	
6	Салбарт ажиллах гүйцэтгэх удирдлага, ажилтан нь дор дурдсан баримт бичгийг бүрдүүлж ирүүлнэ: <ol style="list-style-type: none"> хувьцаа эзэмшигч, гүйцэтгэх удирдлага нь журмын 6-р хавсралтаар баталсан эрх бүхий албан тушаалтны тодорхойлолт, анкет; мэргэжлийн дипломын хуулбар; мөнгөн зээлийн үйл ажиллагааны журмын талаарх гүйцэтгэх удирдлага, менежерийн сургалтад хамрагдсаныг нотлох сертификатын хувь эсхүл сургалт явуулсан эрх бүхий байгууллагын тодорхойлолт; Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хуулийн 5.1.10-т заасан гэмт хэрэгт хариуцлага хүлээж байсан эсэх талаарх эрх бүхий байгууллагын тодорхойлолт; эрх бүхий албан тушаалтан, холбогдох этгээд нь Хорооноос тогтоосон тохиромжтой этгээдэд тавигдах шалгуурыг хангасныг нотлох баримт бичиг; боловсон хүчин, ажилтантай байгуулсан эрх бүхий этгээдийн томилсон шийдвэрийн хувь, хөдөлмөрийн гэрээний хувь 	
7	Үйл ажиллагаа явуулах ажлын байр нь холбогдох шаардлага хангасныг нотлох баримт бичиг, тоног төхөөрөмж, программ хангамж, эд зүйлсийг гэрэл зургаар баталгаажуулах <ol style="list-style-type: none"> ажлын байрны цахилгаан болон галын аюулгүй байдлын шаардлага хангасныг нотлох эрх бүхий байгууллагын дүгнэлт; үйл ажиллагаа явуулах ажлын байр нь өөрийн өмчлөл, эзэмшлийн байр бол үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээний хувь, түрээсийн байр бол түрээсийн гэрээний хувь; 	
8	Зохицуулалтын үйлчилгээний хөлс төлсөн баримт	

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын дөрөвдүгээр хавсралт

БАРЬЦААЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЖУРМААР ОЛГОХ МӨНГӨН ЗЭЭЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ОНООСОН НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ
БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Оноосон нэр өөрчлөх		
Хуучин нэр		Регистрийн дугаар
Шинэчилсэн нэр		
Хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалтын хуудасны огноо	Огноо	
	Дугаар	
Оноосон нэрийг өөрчлөх болсон шалтгаан		
Улсын тэмдэгтийн хураамж	Төлсөн огноо	
	Төлсөн дүн	

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа мэдээлэл, нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв уг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг өөрөө хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, оноосон нэр өөрчлөх хүсэлтийг бүртгэж өгнө үү.

Бид үйл ажиллагаандаа Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд (тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ.):

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Албан тушаал: _____

Утасны дугаар: _____

Өргөдөл гаргагч:

Тэмдэг _____ / _____ /
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

**БАРЬЦААЛАН ЗЭЭЛДҮҮЛЭХ ЖУРМААР ОЛГОХ МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ОНООСОН НЭРИЙН ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ
ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Өргөдөл, хүсэлт тавьсан албан бичиг	
2	Оноосон нэр өөрчлөх тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл, шийдвэр	
3	Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газраас авсан хуулийн этгээдийн оноосон нэрийн баталгаажуулалтын хуудас	
4	Оноосон нэрийг өөрчлөх болсон шалтгааныг тусгасан албан бичиг	
5	Өөрчлөлт оруулсан дүрмийн эх хувь	
6	Бүртгэлийн гэрчилгээ, гэрчилгээний хавсралтын эх хувь	
7	Зохицуулалтын үйлчилгээний хөлс, улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт	

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын тавдугаар хавсралт

МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА,
ХАЯГ БАЙРШЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛ

Өргөдөл гаргасан огноо	Он		Сар		Өдөр	
Өргөдөл гаргагчийн нэр						
Регистрийн дугаар						
Бүртгүүлэх мэдээллийн төрлийг сонгоно уу.						
<input type="checkbox"/> Гүйцэтгэх удирдлагын өөрчлөлт						
<input type="checkbox"/> Хаяг байршлын өөрчлөлт						
Хэсэг 1. Гүйцэтгэх удирдлагад өөрчлөлт оруулах						
Албан тушаал	Овог, нэр		Регистрийн дугаар	Утасны дугаар		
Хэсэг 2. Хаяг байршилд өөрчлөлт оруулах						
Өөрчлөлт оруулсан хаяг байршил	Аймаг/ хот					
	Сум/дүүрэг					
	Баг/хороо					
	Гудамж,байр					
	Тоот					
	Холбоо барих утас					

Бүртгүүлэхээр мэдүүлж байгаа мэдээлэл, нотлох баримтыг бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгсөн бөгөөд хэрэв уг бүрдүүлсэн баримт бичигт аливаа худал ташаа зүйл байвал хариуцлагыг өөрөө хүлээх болно.

Өргөдөл, холбогдох баримт бичгийг хянан шалгаж, гүйцэтгэх удирдлага, хаяг байршил өөрчлөх хүсэлтийг бүртгэж өгнө үү.

Бид үйл ажиллагаандаа Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, журам заавруудыг мөрдлөг болгон ажиллана.

Өргөдөл гаргах эрх бүхий этгээд (тохирохыг сонгож “√” тэмдэглээ хийнэ.):

- Гүйцэтгэх удирдлага
- Үүсгэн байгуулагч, хувьцаа эзэмшигч
- Итгэмжлэлээр эрх олгогдсон бусад этгээд

Овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Албан тушаал: _____

Утасны дугаар: _____

Өргөдөл гаргагч:

Тэмдэг _____ / _____ /
(гарын үсэг) (гарын үсгийн тайлал)

**МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ЭТГЭЭДИЙН ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГА,
ХАЯГ БАЙРШЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ БҮРТГҮҮЛЭХ ӨРГӨДӨЛД ХАВСАРГАХ БАРИМТ
БИЧГИЙН ЖАГСААЛТ**

№	Бүрдүүлэх баримт бичгийн жагсаалт	Хуудасны тоо
1	Өргөдөл, хүсэлт тавьсан албан бичиг	
2	Гүйцэтгэх удирдлага, хаяг байршлыг өөрчлөх тухай эрх бүхий этгээдийн шийдвэр	
3	Гүйцэтгэх удирдлага, боловсон хүчний иргэний цахим үнэмлэх, анкет, мэргэжлийн диплом, гэмт хэрэгт хариуцлага хүлээж байсан эсэх, хугацаа хэтэрсэн өр төлбөртэй эсэх талаарх эрх бүхий байгууллагын лавлагаа тодорхойлолт, тохиромжтой этгээд болохыг нотлох баримт бичиг, холбогдох сургалтад сууж гэрчилгээ авсныг нотлох баримт бичиг, томилсон шийдвэрийн хувь, боловсон хүчин, ажилтантай байгуулсан эрх бүхий этгээдийн хөдөлмөрийн гэрээ, ажлын байрны тодорхойлолт	
4	Үйл ажиллагаа явуулах ажлын байр нь холбогдох шаардлага хангасныг нотлох баримт бичиг, тоног төхөөрөмж, программ хангамж, эд зүйлсийг гэрэл зургаар баталгаажуулах	
5	Улсын тэмдэгтийн хураамж төлсөн баримт	


“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын зургаадугаар хавсралт

ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН БОЛОН
БУСАД БОЛОВСОН ХҮЧНИЙ ТОДОРХОЙЛОЛТ

Эрх бүхий албан тушаалтан болон бусад боловсон хүчний мэдээлэл

1.Ерөнхий мэдээлэл

Ургийн овог:	
Овог нэр:	
Регистрийн дугаар:	
Эрхлэх албан тушаал:	
Оршин суугаа газрын хаяг	
Гар утасны дугаар	
Цахим хаяг	
Эрхэлж байгаа ажил, албан тушаал	
Ажлын хаяг	
Цахим хаяг	



2. Боловсрол/Ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар

3.Ажлын туршлага

№	Хаана ажиллаж байсан	Албан тушаал	Ажилд орсон он, сар, өдөр	Ажлаас гарсан он, сар, өдөр	Шалтгаан

4.ТУЗ-ын дарга, гишүүн, гүйцэтгэх удирдлага бусад боловсон хүчний холбогдох этгээдийн байдал:

Нэгдмэл сонирхолтой этгээдийн мэдээлэл:

№	Таны хэн болох	Овог, нэр /Хуулийн этгээдийн нэр/	Регистрийн дугаар	Эрхэлж буй ажил, албан тушаал

ТОДОРХОЙЛОЛТ ГАРГАСАН:

/..... / /..... / /..... / /..... /
/Албан тушаал/ /Овог, нэр/ /гарын үсэг/ огноо

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын долоодугаар хавсралт

ЭХЛЭЛТИЙН ТАЙЛАН ТЭНЦЭЛ

Хүсэлт гарагч хуулийн этгээдийн нэр	
-------------------------------------	--

ХӨРӨНГӨ	ДҮН	ӨР ТӨЛБӨР, ЭЗДИЙН ӨМЧ	ДҮН
<i>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ</i>		<i>НИЙТ ӨР ТӨЛБӨР</i>	
<i>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө</i>		<i>Богино хугацаат өр төлбөр</i>	
Бэлэн мөнгө		Дансны өглөг	
Банканд байгаа мөнгө		Урьдчилж орсон орлого	
Дансны авлага		Бусад	
Бусад санхүүгийн хөрөнгө		<i>Урт хугацаат өр төлбөр</i>	
Урьдчилж төлсөн зардал			
Богино хугацаат хөрөнгө оруулалт		Хойшлогдсон татварын өр төлбөр	
Бусад эргэлтийн хөрөнгө		Бусад урт хугацаат өр төлбөр	
<i>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ</i>		<i>ЭЗДИЙН ӨМЧ</i>	
Үндсэн хөрөнгө		<i>Хувь нийлүүлсэн хөрөнгө</i>	
Биет бус хөрөнгө		Нэмж төлөгдсөн капитал	
Урт хугацаат хөрөнгө оруулалт		Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	
Бусад эргэлтийн бус хөрөнгө		Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	
		Тусгай зориулалтын нөөцийн сангууд	
		Хуримтлагдсан ашиг/алдагдал	
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	

/..... / /..... / /..... / /..... /

/Албан тушаал/

/Овог, нэр/

/гарын үсэг/

/огноо/

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын наймдугаар хавсралт



**МОНГОЛ УЛСЫН
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО**

БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .

. . . он . . . сар . . . өдөр

Монгол Улсын Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны . . . оны . . . сарын . . . өдрийн . . . дугаар тогтоолыг үндэслэн

“..... барьцаалан зээлдүүлэх газар”-ийг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлд бүртгэж, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

“Тамга”

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын есдүгээр хавсралт



МОНГОЛ УЛСЫН

.....
АЙМАГ/НИЙСЛЭЛ-ИЙН ЗАСАГ ДАРГА
БҮРТГЭЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

Дугаар . . .

. . . он . . . сар . . . өдөр

Монгол Улсын Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул аймаг/нийслэл-ийн засаг даргын оны сарын өдрийн дугаар захирамжийг үндэслэн

“..... барьцаалан зээлдүүлэх газар”

“.....зээлийн үйлчилгээ” иргэн-ийг мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн бүртгэлд бүртгэж, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

“Тамга”

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын аравдугаар хавсралт



МОНГОЛ УЛС

**САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО
МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САЛБАРЫН
ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар . . .

. . . оны . . . сарын . . . өдөр

Монгол Улсын Мөнгөн зээлийн үйл ажиллагааг зохицуулах тухай хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул Санхүүгийн зохицуулах хорооны даргын . . . оны . . . сарын . . . өдрийн тушаалыг үндэслэн хот/аймаг дахь тоот регистрийн дугаар бүхий тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй -д хот/аймаг-ийн дүүрэг/сум-нд дугаартай салбарыг бүртгэж, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

“Тэмдэг”

“Мөнгөн зээлийн үйл ажиллагаа эрхлэх этгээдийн
бүртгэл, үйл ажиллагааны журам”-ын арван нэгдүгээр хавсралт



МОНГОЛ УЛС

**АЙМАГ/НИЙСЛЭЛ-ИЙН ЗАСАГ ДАРГА
МӨНГӨН ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН САЛБАРЫН
ГЭРЧИЛГЭЭ**

Дугаар . . .

. . . оны . . . сарын . . . өдөр

Монгол улсын Мөнгөн зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул аймаг/нийслэл-ийн засаг даргын оны сарын өдрийн захирамжийг үндэслэн хот/аймаг дахь тоот регистрийн дугаар бүхий тоот улсын бүртгэлийн гэрчилгээтэй оноосон нэр бүхий барьцаалан зээлдүүлэх газар-д хот/аймаг-ийн дүүрэг/сум-нд дугаартай салбарыг бүртгэж, энэхүү гэрчилгээг олгов.

ДАРГА

“Тэмдэг”